



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 1/03

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь хэсэг, аймгийн Засаг даргын “Угийн бичиг хөтлөлтийг эрчимжүүлэх тухай” 2017 оны А/д 01 албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголчуудын оршихуйн соёлын нэн үнэт өв “Угийн бичиг”-ээ үеэс үе дамжуулан үр хүүхэддээ өвлүүлэн уламжлах, нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд сурталчлах, өрх бүрээр хөтлүүлэх, бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор “Нэг өрх-нэг угийн бичиг” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Э.Мөнхбаяр (Соёлын төвийн дарга)

Гишүүд: Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)

Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)

Д.Дэмиддавга (6 дугаар багийн Засаг дарга)

Б.Ганням (Эрүүл мэндийн төвийн дарга)

Г.Хорол-Эрдэнэ (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
мэргэжилтэн)

Д.Доржханд (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

С.Буянтогтох (Нийгмийн ухааны багш)

М.Даваадулам (1 дүгээр цэцэрлэгийн арга зүйч)

Б.Жавзмаа (2 дугаар цэцэрлэгийн арга зүйч)

Нарийн бичгийн дарга: Ц.Баасанжав (Насан туршийн боловсролын  
арга зүйч)

2. Сум, багийн түвшинд “Угийн бичиг хөтлөх” ажлыг эрчимжүүлэх, сурталчлах, сургалт, арга зүй, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, захирамжийн хэрэгжилтийн явцыг танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Соёлын төвийн дарга (Э.Мөнхбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

